

ЭТҮГЭН ИХ СУРГУУЛЬД 2026-2027 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД ДОКТОР, МАГИСТР, БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРТ ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

1.1. Этүгэн их сургууль нь оюутан элсүүлэхэд Монгол Улсын “Дээд боловсролын тухай хууль”, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/143 дүгээр тушаалаар батлагдсан “Оюутан элсүүлэх журам”, Боловсрол, Шинжлэх Ухааны Сайдын 2026 оны А/34 дугаар тушаалаар батлагдсан “Босго оноог тогтоох тухай”, 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн “Тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэлийн хөтөлбөрөөр оюутан элсүүлэхэд зохицуулалт хийх тухай” А/211 дугаар тушаал, Этүгэн их сургуулийн Сургалтын нэгдсэн журам болон бусад холбогдох эрх зүйн баримт бичгүүд болон энэхүү журам (цаашид “Журам” гэх) -ыг тус тус баримтална.

1.2. Сургуулийн талаар болон элсэлтийн журам, элсэлттэй холбогдох нэмэлт мэдээллийг www.etugen.edu.mn веб сайт, **Этүгэн их сургууль** facebook page хуудас болон тараах хуудсаар авч болно.

1.3. Этүгэн их сургуулийн дэд бакалавр, бакалавр, магистр, докторын хөтөлбөрт элсэхээр хүсэлт гаргасан иргэнийг “бүртгүүлэгч”, зохих шаардлага хангасан бүртгүүлэгчдэд олгох бичиг баримтыг “суралцах эрхийн бичиг”, элсүүлэх суралцагчийн тоог “хяналтын тоо”, хяналтын тоонд багтан элсэх эрхээ баталгаажуулж, суралцах эрхийн бичиг олгогдсон бүртгүүлэгчийг “элсэгч”, элсэлтийн цахим бүртгэлийн систем (<http://burtgel.etugen.edu.mn>)-ийг “элсэлтийн бүртгэлийн систем”, элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахаар томилогдсон ажлын хэсгийг “элсэлтийн комисс” гэнэ.

1.4. Этүгэн их сургуулийн дэд бакалавр, бакалавр, магистр, докторын хөтөлбөрт элсүүлэх элсэгчийн хяналтын тоог Удирдах зөвлөл тогтооно. Удирдах зөвлөлөөс баталсан хяналтын тоонд багтаан элсэлтийн үйл ажиллагааг жилд 2 хүртэл удаа зохион байгуулж болно.

1.5. Ур чадварын шалгалт өгөх тохиолдолд Этүгэн их сургуулийн ректорын тушаалаар Ур чадварын шалгалтын комиссын бүрэлдэхүүнийг томилно. Комисс нь ур чадварын шалгалтыг Хавсралт 2- д заасан удирдамжийн дагуу зохион байгуулна.

1.6. Этүгэн их сургуульд гадаадын харьяат иргэдийг элсүүлэх асуудлыг “Этүгэн их сургуульд гадаадын иргэнийг суралцуулах журам”-аар тусад нь зохицуулна.

ХОЁР. ЭЛСЭЛТИЙН КОМИССЫН БҮТЭЦ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. Элсэлтийн комиссын бүрдэлдэхүүнийг Этүгэн их сургуулийн ректорын тушаалаар томилно.

2.2. Этүгэн их сургуулийн элсэлтийн комисс нь Сургуулийн удирдах зөвлөлийн дарга, Сургалт эрхэлсэн дэд захирал, элсэлт хариуцсан менежер, гишүүд нь бүрэлдэхүүн сургууль, алба нэгжийн албан тушаалтнууд байна.

2.3. Элсэлтийн төлөвлөгөөг боловсруулж, элсэлтийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар ханган хэрэгжилтэд хяналт тавина.

2.4. Элсэлтийн бүртгэлийг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллана.

2.5. Этүгэн их сургуулийн элсэлтийн комисс элсэлтийг уламжлалт болон цахим хэлбэрээр зохион байгуулна.

2.6. Аймаг, орон нутагт томилогдсон багш цахим бүртгэлд хэрхэн амжилттай бүртгүүлэх талаар болон сургуулийн мэдээллийг өгч эсээ бичүүлж, ярилцлага хийх бөгөөд

шаардлага хангасан элсэгчдэд элсэлтийн комиссоос олгосон хяналтын тооны дагуу суралцах эрхийн бичиг олгоно.

2.7. Бүртгэлийн хугацаа дууссаны дараа хяналтын тоо үлдсэн тохиолдолд элсэлтийн комисс нөхөн элсэлтийг цахимаар зохион байгуулна.

**ГУРАВ.ХӨТӨЛБӨР, ЭЛСҮҮЛЭХ МЭРГЭЖИЛ,
ЭЛСЭЛТИЙН ЕРӨНХИЙ ШАЛГАЛТ, БОСГО ОНОО**

Бүрэлдэхүүн сургууль	Сонгох боломжтой бакалаврын мэргэжлийн хөтөлбөр	Боловсролын зэрэг	Суралцах жил, хэлбэр	Элсэлтийн ерөнхий шалгалт, босго оноо	
				Элсэлтийн шалгалт-1	Элсэлтийн шалгалт-2
Эрүүл мэндийн сургууль	Уламжлалт анагаах ухааны их эмч	бакалавр	6 (өдөр)	Хими, Математик (440)	Физик, Биологи (490)
	Анагаах ухаан- Хүний их эмч		6 (өдөр)	Хими Математик (490)	Биологи, Физик (490)
	Био-анагаах ухаан **		5 (өдөр)	Хими, Математик (480)	Биологи, Физик (490)
Эм зүйн сургууль	Эм зүйч	бакалавр	5 (өдөр)	Хими, Математик (490)	Биологи, Физик (490)
	Эм найруулагч *	дэд бакалавр	3 (өдөр)	Хими, Биологи (410)	Математик, Биологи, Хими, Англи хэл, Физик, Монгол хэл, Нийгэм судлал, Ур чадвар (сорил) (410)
Нүүр ам судлалын сургууль	Нүүр ам судлал-Шүдний их эмч	бакалавр	5 (өдөр)	Хими, Математик (490) Хими, Биологи (430)	Физик, Биологи (490)
Сувилахуйн сургууль	Сувилахуй *	бакалавр	4 (өдөр)		Хими, Биологи (410)
	Олон улсын сувилахуй *			дэд бакалавр	
	Сувилахуй *	бакалавр	4 (өдөр)		Хими, Биологи (440)
	Хөдөлгөөн засал* (хамтарсан хөтөлбөр)			бакалавр	
Хүмүүнлэгийн сургууль	Нягтлан бодох бүртгэл	бакалавр	4 (өдөр)	Математик (490)	Англи хэл, Нийгэм судлал (490)
	Санхүү, банк				
	Татварын эдийн засаг, нягтлан бодох бүртгэл				
	Хүний нөөцийн менежмент				
	Бизнесийн удирдлага				
	Маркетинг				
	Нийтийн удирдлага (Төрийн захиргааны удирдлага)	бакалавр	4 (өдөр)	Нийгэм судлал, Математик (490)	Англи хэл, Нийгэм судлал (490)
Аялал жуулчлал*	бакалавр	4 (өдөр)	Газарзүй,	Математик, Биологи,	

				Математик Англи хэл (490)	Хими, Англи хэл, Физик, Монгол хэл, Нийгэм судлал, Ур чадвар (сорил) (490)
	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний технологи	бакалавр	4 (өдөр)	Хими, Физик, Математик (490)	Англи хэл, Нийгэм судлал (450)
Инженер, технологийн сургууль	Программ хангамжийн инженер	бакалавр	4 (өдөр)	Математик Физик (490)	Англи хэл, Нийгэм судлал (450)
	Big Data* (хамтарсан хөтөлбөр)				
	VR технологи * (хамтарсан хөтөлбөр)				
	Цахилгаан хангамжийн инженер **				
	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалтын инженер **				
Багшийн сургууль	Багш, бага боловсрол *	бакалавр	4 (өдөр)	Монгол хэл, Математик (450)	Математик, Англи хэл, Физик, Монгол хэл, Нийгэм судлал, Ур чадвар (сорил) (490)
	Багш, сургуулийн өмнөх боловсрол*	бакалавр	4 (өдөр)	Нийгэм судлал, Монгол хэл, Математик (440)	
	Багш, математикийн боловсрол*	бакалавр	4 (өдөр)	Математик, Физик (490)	
Цахим сургалтын хөтөлбөр					
Сувилахуй (дэд бакалаврын боловсролоос)		бакалавр	1 (орой)	Мэргэжил	
Нягтлан бодох бүртгэл			2-2.5 (орой, эчнээ, цахим)		
Төрийн захиргааны удирдлага					
Доктор, магистрын хөтөлбөр					
Анагаах ухаан		магистр	2 жил	Мэргэжил, Англи хэл, Ярилцлага	
Нүүр ам судлал					
Эм зүй					
Био-анагаах ухаан					
Уламжлалт анагаах ухаан					
Сувилахуй					
Бизнесийн удирдлага			1.5-2.5 (өдөр, эчнээ, цахим)		
Нягтлан бодох бүртгэл					
Төрийн захиргааны удирдлага					
Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт		доктор	4 жил		
Анагаах ухаан					

* Дээд боловсролын тэргүүлэх мэргэжлийн чиглэл

** Дээд боловсролын эрэлттэй мэргэжлийн чиглэл

*** Элсэлтийн явцыг үндэслэн нэмэлт элсэлт хийх шаардлага үүсвэл үүнтэй холбогдсон өөрчлөлтийг тухай бүрд нь зарлана.

ДӨРӨВ.БАКАЛАВРЫН ЭЛСЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БҮРТГҮҮЛЭГЧДЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

4.1. Элсэхийг хүсэгч нь бүрэн дунд, түүнээс дээш боловсрол эзэмшсэн болохыг нотолсон гэрчилгээтэй, Боловсролын үнэлгээний төвийн элсэлтийн шалгалтын хүчинтэй батламжтай, (2 жил 6 сарын хугацаанд хүчинтэй) эсвэл 2026 онд элсэлтийн шалгалт өгөхөөр Боловсролын үнэлгээний төвд бүртгүүлсэн байна. Бүртгүүлэгч нь Этүгэн их сургуулийн оюутан бол бүртгүүлэх боломжгүй.

4.2. Боловсролын үнэлгээний төвөөс зохион байгуулах элсэлтийн ерөнхий шалгалтыг энэ журмын 3-т заасан тухайн хөтөлбөрт шаардагдах хичээлээр өгч, Боловсрол, шинжлэх ухааны яамнаас тогтоосон босго оноог хангасан байна.

4.3. Гадаад оронд ерөнхий боловсрол эзэмшсэн Монгол улсын иргэн БШУЯ-ны сайдын 2021 оны А/347 тоот тушаалаар баталсан “Олон улсын шалгалтын үнэлгээг Монгол улсын элсэлтийн ерөнхий шалгалтын үнэлгээтэй дүйцүүлэн тооцох журам”-ыг баримтална. Мөн гадаад улс орны ерөнхий боловсролын шалгалтын оноог Боловсролын үнэлгээний төвөөр дүйцүүлсэн батламжтай байна.

ТАВ. ЭЛСЭХ ХҮСЭЛТ ГАРГАХ

5.1. Элсэхийг хүсэгч Улаанбаатар хотын төв комисс болон орон нутагт ажиллаж буй багшид өөрийн биеэр ирж бүртгүүлэх болон элсэлтийн цахим бүртгэлийн аль нэг хэлбэрийг сонгож бүртгүүлнэ.

5.2. Элсэхийг хүсэгч нь орон нутаг болон хотоос цахим хэлбэрээр (<http://burtgel.etugen.edu.mn/>)-бүртгэлийн системийн бакалавр, дэд бакалаврын элсэлт хэсэгт бүртгүүлнэ. Элсэлтийн цахим бүртгэлийн систем 2026 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр нээгдэж, 06 дугаар сарын 30-ны өдрийн 18:00 цагт хаана. *(элсэлтийн комиссын шийдвэрээр хаагдах хугацааг өөрчилж болно)*

5.3. Цахимаар бүртгүүлэгч нь Боловсролын үнэлгээний төвийн системд бүртгүүлсэн бүртгэлийн дугаар, нууц үгээ ашиглан элсэлтийн системд нэвтэрнэ. Зааврын дагуу хувийн мэдээлэл, цахим шуудангийн хаяг, утасны дугаар болон шаардлагатай мэдээллийг алдаа мадаггүй үнэн зөв оруулж баталгаажуулан бүртгүүлнэ. Өмнө нь хэд хэдэн удаа элсэлтийн ерөнхий шалгалт өгсөн бол сүүлийн бүртгэлийн дугаараар хүсэлт гаргаж бүртгүүлнэ.

5.4. Цахим хэлбэрээр бүртгүүлэгч хувийн мэдээллээ шалгаж баталгаажуулсны дараа сонирхсон мэргэжил (хөтөлбөрөө)-с сонгож, бүртгэлийн хураамжийг цахим хэлбэрээр төлж баталгаажуулна. (Төлбөр төлөх тухай дэлгэрэнгүй зөвлөмжийг элсэлтийн системээс үзнэ үү)

5.6. Бүртгүүлэгч нь нэг хураамжаар элсэлтийн ерөнхий шалгалтын сонгосон хичээлээ харгалзан 4-өөс илүүгүй мэргэжил (хөтөлбөрт) зэрэг бүртгүүлж болно.

5.5. Элсэлтийн системд бүртгүүлэгчийн оруулсан алдаатай мэдээллээс хамааран мэргэжлийн (хөтөлбөр) сонголтыг хийж чадаагүй бол үүсэх асуудлыг Этүгэн их сургууль хариуцахгүй.

ЗУРГАА. ЭЛСЭГЧИЙГ ШАЛГАРУУЛАХ, ЭЛСЭХ ЭРХ ОЛГОХ

6.1. Улаанбаатар хот дахь Этүгэн их сургуулийн хувьд "Элсэлтийн шалгалт-1" болон "Элсэлтийн шалгалт-2" шалгалтад тооцохоор заасан хичээлээс хамгийн өндөр оноо авсан хоёр хичээл тус бүрээр, Эрдэнэт салбар сургуулийн хувьд элсэгчдийн хангасан байх босго 430 онооноос багагүй байна.

6.2. Анагаах ухаан-Хүний их эмч, Нүүр ам судлал-шүдний их эмчээс бусад мэргэжлээр (хөтөлбөр) бүртгүүлэгч "Элсэлтийн шалгалт-1" болон "Элсэлтийн шалгалт-2" шалгалтад тооцохоор заасан хичээлийн босго оноог хангасан бол хяналтын тоонд багтаан

элсэлтийн ерөнхий шалгалтын нэгдсэн дүн олон нийтэд зарласан өдрөөс эхлэн шууд элсүүлж, суралцах эрхийн бичиг олгоно.

6.3. Анагаах ухаан-хүний их эмч, Нүүр ам судлал-шүдний их эмч мэргэжлээр бүртгүүлэгчдийг онооны дарааллаар жагсаан шалгаруулж, элсэх эрхийг холбоо барьж мэдэгдэнэ. Мөн бүртгүүлэгч хяналтын тоонд багтсан эсэхээ онооны жагсаалт гарсны дараа элсэлтийн системд нэвтэрч шалгана.

6.4. Элсэлтийн ерөнхий шалгалтын оноо тэнцсэн тохиолдолд бүрэн дунд боловсролын гэрчилгээний дундаж дүнг харгалзан шийдвэрлэнэ.

6.5. Улаанбаатар хот, орон нутгаас цахимаар бүртгүүлсэн элсэхийг хүсэгч тухайн хөтөлбөрийн босго оноог ханган хяналтын тоонд багтсан бол элсэх эрхийг холбоо барих утсаар мэдэгдэн, орон нутагт ажиллаж буй багш болон элсэлтийн төв комисст заасан хугацаанд бичиг баримттайгаа өөрийн биеэр ирснээр суралцах эрхийн бичгийг олгоно.

6.6. Эсвэл хяналтын тоонд багтсан цахимаар бүртгүүлсэн элсэхийг хүсэгч элсэн суралцах эрхээ баталгаажуулан 250.000 төгрөг төлснөөр, элсэлтийн цахим бүртгэлийн системээс суралцах эрхийн бичгийг авч болно. Энэ төлбөрийг суралцагчийн 2026-2027 оны хичээлийн жилийн сургалтын төлбөрөөс тооцож хасна.

6.7. Хяналтын тоонд багтаагүй элсэхийг хүсэгч элсэлтийн ерөнхий шалгалт нь ижил хичээлээр өгөгдсөн бол орон тоо байгаа өөр мэргэжлээр (хөтөлбөр) шилжин элсэж болно.

6.8. Ур чадварын шалгалтаар тооцох мэргэжил (хөтөлбөр)-ээр элсэгчдээс Хавсралт 1-ээр батлагдсан удирдамжийн дагуу шалгалтыг авч 100 хүртэл оноогоор үнэлнэ. Уг оноог хэмжээст оноонд харгалзуулан тооцно.

6.9. Гадаадын оронд ерөнхий боловсрол эзэмшсэн иргэдийн өргөдлийг Элсэлтийн комисс тусад нь хүлээн авч шийдвэрлэнэ.

6.10. Этүгэн их сургуулийн дэргэдэх бүрэн дунд сургуулийн төгсөгчдийг элсэлтийн ерөнхий шалгалтын оноог харгалзан хяналтын тоонд багтаан элсүүлнэ.

ДОЛОО. БҮРТГҮҮЛЭХ

7.1. Суралцах эрхийн бичиг авсан хот болон орон нутгийн элсэгчид 2026 оны 08 дугаар сарын 20-31-ний өдрүүдэд хичээлийн 2-р байранд өөрийн биеэр ирж бүртгүүлнэ. Бүртгүүлэхдээ дараах бичиг баримтыг бүрдүүлсэн байна. Үүнд:

1. Иргэний үнэмлэх хуулбарын хамт (ар, өвөр тал нэг нүүрт);
2. Суралцах эрхийн бичиг;
3. Бүрэн дунд боловсролын гэрчилгээ (хэрэв түүнээс дээш шатны боловсрол эзэмшсэн бол гэрчлэх баримт бичиг, хуулбарын хамт);
4. Элсэлтийн ерөнхий шалгалтын оноо (цахим системээс гаргасан);
5. 3х4 хэмжээтэй цээж зураг – 3% (сүүлийн 3 сар дотор авхуулсан);
6. Сургалтын төлбөр төлсөн баримт (Нэгдүгээр дамжааны анхлан элсэгч нь сургуульд бүртгүүлэхээр ирэхдээ тухайн хичээлийн жилийн сургалтын төлбөрийг төлсөн байна);
 - **Хаан банк MN850005005041043371,**
 - **Голомт банк MN790015002205116544,**
 - **Хас банк MN510032005001115493,**
 - **Худалдаа хөгжлийн банк MN520004002615008055,**
 - **Капитрон банк MN190030003000001222**
7. Боловсролын зээлийн сангийн буцалтгүй тусламжаар суралцах бол холбогдох материал, тухайн хичээлийн жилийн сургалтын төлбөрийн 50 хүртэл хувь төлсөн баримт;
8. Бичиг баримтын үнэ (30000 төгрөг);

7.2. Энэхүү журмын 7.1.-д заасан хугацаанд бүртгүүлээгүй элсэгчийг Этүгэн их сургуульд суралцахаас татгалзсан гэж үзэн суралцах эрхийг хүчингүйд тооцно.

7.3. Элсэгчийн бүрдүүлсэн бичиг баримт нь хуурамчаар үйлдсэн, зөрчилтэй нь тогтоогдвол Этүгэн их сургуульд элсүүлэхгүй.

НАЙМ. ЭЛСЭГЧДЭД ҮЗҮҮЛЭХ ТЭТГЭЛЭГ, ХӨНГӨЛӨЛТ

8.1. Монгол Улсын Засгийн Газрын сургалтын төлбөрийн тэтгэлэг

8.1.1. Био-Анагаах ухаан, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалтын инженер, Цахилгаан хангамжийн инженер зэрэг тэргүүлэх мэргэжилд элсэн суралцаж буй суралцагчдын элсэлтийн шалгалт I хичээл 600 онооноос дээш, голч дүн 3.0-аас дээш бол сургалтын төлбөрийн 100% -ийн тэтгэлэг олгоно.

8.1.2. Сувилагч мэргэжлээр элсэн суралцаж буй суралцагчдын элсэлтийн шалгалт I хичээл 501 онооноос дээш, голч дүн 2.8-3.0 бол 70%, 3.0-аас дээш бол 100%-ийн сургалтын төлбөрийн тэтгэлэг олгоно.

8.1.3. Багш, бага боловсрол, багш, сургуулийн өмнөх боловсрол мэргэжлээр элсэн суралцаж буй суралцагчдын элсэлтийн шалгалт I хичээл 520 онооноос дээш, голч дүн 2.8-аас дээш бол сургалтын төлбөрийн 100%-ийн тэтгэлэг олгоно.

8.1.4. Монгол улсын иргэн байх, элсэлтийн журмын дагуу элссэн, эрэлттэй болон тэргүүлэх хөтөлбөр, суралцах хөтөлбөр магадлан итгэмжлэгдсэн байх, суралцагч суралцаж төгсөөд хөдөө орон нутагт 3-аас доошгүй, эсвэл нийслэлд 5-аас доошгүй жил тогтвортой ажиллах заасан шаардлагыг хүлээн зөвшөөрч гэрээ байгуулснаар тэтгэлэг баталгаажна.

8.2. Этүгэн их сургуулийн “Этүгэн сан”-ийн тэтгэлэг

8.2.1. Авьяасыг тэтгэнэ.

Элсэлтийн ерөнхий шалгалтын жагсаалтад мэргэжлийн бүлэгтээ Улаанбаатар хот болон аймагтаа тэргүүлэгчдэд тухайн жилийн болон суралцах бүх хугацааны сургалтын төлбөрийн тэтгэлэг олгоно.

а. Тухайн жилийн сургалтын төлбөрийн тэтгэлэг олгоно.

1-5 байрт жагссан, эсвэл 760-800 оноо авсан бол*	100%
6-10 байрт жагссан, эсвэл 720-759 оноо авсан бол	50%
11-15 байрт жагссан, эсвэл 700-719 оноо авсан бол	25%
16-20 байрт жагссан, эсвэл 650-699 оноо авсан бол	15%

б. *100% тэтгэлэг хүртэгсэд 3.2-оос дээш голч дүнтэй суралцсан бол төгстлөө 100% тэтгэлэгтэй суралцана.

8.2.2. Олимпиадын амжилтыг тэтгэнэ.

Олон улс, улсын болон аймаг, нийслэл түүнтэй дүйцэхүйц олимпиадад амжилттай оролцсон элсэгчийг онооны дараалал харгалзахгүй тухайн мэргэжлээр шууд элсүүлнэ.

1 байр**	100%	Олон улс, улсын олимпиадад гаргасан амжилтаас хамаарч тухайн жилийн болон суралцах бүх хугацааны сургалтын төлбөрийн тэтгэлэг олгоно.
2-5 байр**	70%	
6-10 байр	50%	
11-15 байр	30%	

**Олимпиадад 1-5 байр эзлэгсэд голч дүн 3.2-оос дээш суралцвал тэтгэлгийг суралцан төгстөл нь үргэлжлүүлэн олгоно.

1 байр	50%	Аймаг, нийслэл түүнтэй дүйцэхүйц олимпиад, Этүгэн их сургуулийн
2-5 байр	30%	

6-10 байр	20%	уламжлалт олимпиад, сорилгод үзүүлсэн амжилтаас хамаарч эхний жилийн сургалтын төлбөрийн тэтгэлэг олгоно..
11-15 байр	10%	

8.2.3. Гоц авьяастай элсэгч, энхийн үйлсэд онцгой гавьяа байгуулагсад, өөрийгөө сургуулийн элсэлтийн төв комиссын өмнө нотолбол, суралцах бүх үеийн турш, эсхүл тухайн жилд хэдэн хувиар хөнгөлөлт үзүүлэхийг тодорхойлуулан суралцаж болно. Гоц авьяас гэдэг ойлголтод ямар нэг хязгаарлалт тавихгүй. (спорт, урлаг, онцгой мэдрэмжүүд гэх мэт)

8.2.4. Захиалгат мэргэжилтнийг дэмжинэ. Мэргэжилтэн дутагдалтай орон нутаг, байгууллагын захиалгатай суралцагчийг хяналтын тоонд багтаан элсүүлж болно.

8.3. Элсэгчийн дээрх хөнгөлөлт давхардсан тохиолдолд элсэгч аль нэгийг нь сонгоно.

8.4. Бакалаврын түвшний суралцагч сургуулийн тогтоосон шаардлагыг хангасан тохиолдолд төгсөх дамжаанд тухайн магистрын хөтөлбөрийн хичээлийг нэмэлтээр судалж болно. Магистрын хөтөлбөрт элссэн тохиолдолд амжилттай судалсан хичээлийг дүйцүүлэн тооцож хос дипломтой төгсөх боломжтой.

8.5. Этүгэн их сургуульд элссэн оюутан нь үндсэн мэргэжлээр суралцах хугацаанд өөр чиглэлээр зэрэгцэн “Хавсарга хөтөлбөр”-ийг сонгон суралцаж болно. “Хавсарга хөтөлбөр”-өөр суралцсанаар нэмэлт ур чадвар эзэмшсэн гэрчилгээг дипломтой хамт олгоно. (Хавсралт 1)

ЕС . ЭЛСЭЛТИЙН ЕРӨНХИЙ ШАЛГАЛТГҮЙГЭЭР БАКАЛАВРЫН

ХӨТӨЛБӨРТ ЭЛСҮҮЛЭХ

9.1. Боловсрол Шинжлэх Ухааны Сайдын 2024 оны А/143 тушаалаар баталсан “Оюутан элсүүлэх журам”-ын 2.4 дахь заалтын шалгуурыг хангасан иргэнээс элсэлтийн ерөнхий шалгалт шаардахгүйгээр бичиг баримтыг үндэслэн хяналтын тоонд багтаан элсүүлнэ. Үүнд:

9.1.1. Дэд бакалавр, бакалаврын боловсролтой иргэн;

9.1.2. Политехник коллеж, шаталсан сургалттай дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөгч тухайн мэргэжлийн чиглэлээр дэд бакалавр, бакалаврын хөтөлбөрт элсэх иргэн;

9.1.3. Элсэн суралцах мэргэжлийн чиглэл (хөтөлбөр)-ээр 3-аас доошгүй жил ажилласан, 30-аас дээш насны иргэн;

9.1.4. Гадаад болон дотоодын ерөнхий боловсролын сургуульд суралцаж бүрэн дунд боловсрол эзэмшин, олон улсад нийтлэг хүлээн зөвшөөрөгддөг шалгалтын дүн, оноог Боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллагаар дүйцүүлэн тооцуулж батламж авсан иргэн;

9.1.5. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хүлээн зөвшөөрсөн олон улсын болон улсын төрөлжсөн олимпиадын эхний 5 байрт шалгарсан иргэн тухайн чиглэлийн хөтөлбөрт;

9.1.6. Гадаадын аль нэг улсын дээд боловсролын сургалтын байгууллагаас Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагын ижил түвшний хөтөлбөрт шилжин суралцах иргэн;

9.2. Бүртгүүлэхдээ дараах бичиг баримтыг хавсарган элсэлтийн комисст өөрийн биеэр ирж бүртгүүлнэ.

- Иргэний үнэмлэх хуулбарын хамт (ар, өвөр тал нэг нүүрт)
- Бүрэн дунд боловсролын гэрчилгээ (хуулбарын хамт)

- Өмнө эзэмшсэн боловсролын диплом, хавсралтын хамт (гадаад хэлээр бол монгол хэл рүү орчуулан нотариатаар гэрчлүүлсэн байна)
- 3x4 хэмжээтэй цээж зураг – 3% (сүүлийн 3 сар дотор авхуулсан)
- Өргөдөл

9.3. Бакалаврын болон дэд бакалаврын боловсрол эзэмшсэн элсэхийг хүсэгчид сургуулийн байранд өөрийн биеэр ирж бүртгүүлэх бөгөөд өмнөх боловсролын дипломын дундаж дүн, мэргэжлээрээ ажилласан жил болон ажиллаж буй байгууллага, аж ахуйн нэгжийн захиалгыг үндэслэн ерөнхий шалгалтын оноо харгалзахгүйгээр өмнөх боловсролын дипломын багц цагийг дүйцүүлэн тооцож тохирох дамжаанд сургах асуудлыг элсэлтийн комиссын саналыг үндэслэн ректорын тушаалаар баталгаажуулан элсүүлнэ.

9.4. Сувилахуй, Нягтлан бодох бүртгэл, Төрийн захиргааны удирдлага мэргэжлээр (хөтөлбөр) орой, эчнээ, цахим хөтөлбөрт элсэхийг хүсэгчдийн өмнө нь эзэмшсэн мэргэжлийн дипломыг үндэслэн элсүүлнэ.

АРАВ. ХАМТАРСАН БОЛОН ОЮУТАН СОЛИЛЦООНЫ ХӨТӨЛБӨР

10.1. Хамтарсан хөтөлбөр

БНСУ-ын Намсүүл сургуулийн хамтарсан хөтөлбөр: (Суралцах хугацаа 2+1+2)

10.1.1. Хамтарсан хөтөлбөрийн мэргэжлийн чиглэл:

- Программ хангамж
- Big Data
- VR технологи
- Хөдөлгөөн засал
- Бизнесийн удирдлага
- Маркетинг
- Аялал жуулчлал

10.1.2. Хамтарсан хөтөлбөрийн суралцах хугацаа, дамжаа:

- Этүгэн их сургуульд I, II дамжаанд 2 жил суралцах
- Хэлний бэлтгэлд 1 жил суралцах
- Намсүүл сургуульд III, IV дамжаанд 2 жил суралцах

10.1.3. Этүгэн их сургуульд 2 жил 65 багц цагийг судлах бөгөөд 3.0 ба түүнээс дээш голч дүнтэй, солонгос хэлний анхан шатны сургалтад амжилттай суралцсан тохиолдолд Намсүүл сургуулийн хэлний бэлтгэлд сургалтын төлбөрийн 100 хувийн тэтгэлэгтэй 1 жил суралцана.

10.1.4. Хэлний бэлтгэлийн хувьд солонгос хэлний түвшин тогтоох шалгалтын түвшин Хөдөлгөөн засал мэргэжилд (TOPIK) 4-өөс дээш, бусад мэргэжилд (TOPIK) 3-аас дээш өгсөн тохиолдолд үндсэн мэргэжлийн III дамжааны 1 дүгээр улиралд элсэн суралцахад хэлний онооны 1,000,000 воны тэтгэлэг, сургалтын төлбөрөөс 40 хувийн тэтгэлэг олгоно.

10.1.5. Голч дүнгээс хамаарсан III дамжааны 2 дугаар улирал, IV дамжааны нэг жилийн сургалтын төлбөрийн дараах тэтгэлэг олгох бөгөөд гадаад оюутны 40 хувийн хөнгөлөлт олгоно.

- 4.0-с дээш голч дүн, сургалтын төлбөрийн 40%
- 3.5-3.99 голч дүн, сургалтын төлбөрийн 35%
- 3.0-3.49 голч дүн, сургалтын төлбөрийн 30%

10.1.6. Хамтарсан хөтөлбөрөөр суралцсанаар Этүгэн их сургууль, Намсөүл сургуулийн хос дипломтой төгсөнө.

БНХАУ-ын Шиньяны Багшийн их сургуультай хамтарсан хөтөлбөр: (Суралцах хугацаа 3+1)

10.1.7. Хамтарсан хөтөлбөрийн мэргэжлийн чиглэл:

- Программ хангамж
- Багш сургуулийн өмнөх боловсрол

10.1.8. Хамтарсан хөтөлбөрийн суралцах хугацаа, дамжаа:

- Этүгэн их сургуульд I, II, III дамжаанд 3 жил суралцах
- Шиньяны багшийн их сургуульд IV дамжаанд 1 жил суралцах

10.1.9. Хамтарсан хөтөлбөрөөр суралцсанаар Этүгэн их сургууль, Шиньяны багшийн их сургуулийн хос дипломтой төгсөнө.

10.2. Оюутны солилцооны хөтөлбөр

10.2.1. БНСУ-ын Kyungwoon, Handong Global, Andong National, Semyang их сургуульд солонгос хэлний түвшин тогтоох шалгалтын (TOPIK) 3-аас дээш түвшин хангасан суралцагчид нэг улирал очиж суралцаад, Этүгэн их сургуульд багц цаг дүйцүүлэн үргэлжлүүлэн суралцана. Байр, хоол хэрэглээний зардлаа хувь хүн хариуцна.

Kyungwoon University

- Сувилахуй
- Хөдөлгөөн засал
- Нүүр ам судлал
- Био-Анагаах ухаан

Handong Global University

- Бизнесийн удирдлага
- Нягтлан бодох бүртгэл
- Маркетинг
- Аялал жуулчлал

Andong National University

- Бизнесийн удирдлага
- Нийтийн удирдлага (Төрийн захиргааны удирдлага)

Semyang University

- Бакалавр, магистрын хөтөлбөрийн хүрээнд 1 сараас 1 жил хүртэл хугацаатай суралцана.

10.3. Дадлагажигч оюутны хөтөлбөр

10.3.1. Япон улсад цалинтай “Дадлагажигч оюутан” хөтөлбөрт хамрагдах боломжтой.

- Анагаах ухаан-Хүний их эмч
- Бизнесийн удирдлага
- Маркетинг
- Аялал жуулчлал
- Нягтлан бодох бүртгэл
- Хүний нөөцийн менежмент
- Сувилахуй
- Багш, сургуулийн өмнөх боловсрол
- Инженерийн хөтөлбөр

АРВАН НЭГ. АХИСАН ТҮВШНИЙ (ДОКТОР, МАГИСТР) СУРГАЛТЫН ЭЛСЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

11.1. Этүгэн их сургуулийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хөтөлбөрөөр магистрант, докторантыг элсүүлнэ.

11.2. Магистрын хөтөлбөрт бакалаврын зэрэгтэй, докторын хөтөлбөрт магистрын зэрэгтэй бүртгүүлэгчийг элсүүлнэ.

11.3. Анагаах ухааны магистрын зэрэгтэй элсэхийг хүсэгчийг Анагаах ухааны докторын хөтөлбөрт элсүүлнэ.

11.4. Магистрын хөтөлбөрт элсэхийг хүсэгч нь тухайн элсэх мэргэжлийн чиглэлээр бакалаврын зэрэгтэй төгссөн байна.

11.5. Магистрын хөтөлбөрт элсэхийг хүсэгч нь өмнө эзэмшсэн бакалаврын мэргэжлээс өөр чиглэлээр магистрын хөтөлбөрт хамрагдах бол сургалтын агуулгын залгамж чанарыг хангахад шаардагдах хичээлийн зөрүүг нөхөн үзнэ. Нөхөн үзсэн хичээлийг магистрын хөтөлбөрийн үндсэн багц цагт тооцохгүй.

11.6. Гадаадын иргэн Монгол улсад мөрдөж буй боловсролын агуулгын түвшин, стандартад дүйцэх магистрын боловсрол эзэмшсэн байна.

11.7. Элсэлттэй холбоотой мэдээллийг сургуулийн www.etugen.edu.mn веб сайт, **Этүгэн их сургууль** facebook page хуудаст байршуулж, элсэлтийн бүртгэлийн системийг нээнэ.

11.8. Элсэлтийг хичээлийн жилд хоёр удаа зохион байгуулна. Магистр, докторын хөтөлбөрийн элсэлтийн бүртгэлийг цахим хэлбэрээр явуулах бөгөөд намрын улирлын элсэлтийг 07 сарын 16-ноос 09 сарын 15-ныг дуустал, хаврын улирлын элсэлтийг 11 дүгээр сарын 10-наас 01 сарын 15-ныг дуустал бүртгэлийн систем (<http://burtgel.etugen.edu.mn/>)-ийн магистр, докторын элсэлт хэсгээр явуулна.

11.9. Бүрэлдэхүүн сургуулийн саналыг үндэслэн сургалтын үйл ажиллагааг ажлын бус өдөр (бямба, ням) зохион байгуулах хэлбэрээр тухайлсан хөтөлбөрт элсэлтийг авч болно.

11.10. Бүртгүүлэгч нь элсэлтийн бүртгэлийн системд анкетыг бөглөж, өөрийн гар утасны дугаар, цахим шуудангийн хаягийг заавал бөглөх бөгөөд эдгээр мэдээллийн үнэн зөв байдлыг бүртгүүлэгч өөрөө хариуцна. Дараах бичиг баримтыг цахим хэлбэрээр хавсаргана.

- Иргэний үнэмлэх эсвэл түүнтэй адилтгах баримт бичгийн хуулбар;
- Эзэмшсэн боловсролын диплом, түүний хавсралтын хуулбар;
- Цээж зураг;

11.11. Тус журмын 11.9-т заасан баримт бичиг нь гадаад хэлээр бол Монгол хэлээр орчуулан, нотариатаар батлуулсан байна.

11.12. Бүртгүүлэгч элсэлтийн шалгалтад тэнцсэн зөвхөн нэг хөтөлбөрт элсэх эрхтэй.

11.13. Бүртгүүлэгч нь элсэх мэргэжлийн чиглэлийн дагуу шалгалт өгнө. Шалгалтын зохион байгуулалтыг элсэлтийн комисс хариуцна.

11.14. Элсэлтийн шалгалт нь шалгуулагчийн мэдлэг, чадварыг тодорхойлохуйц агуулгатай сорил болон бичиг, ярилцлага, англи хэлний шалгалт зэрэг хэлбэртэй байна.

11.15. Бакалаврын зэргийн боловсролын дипломын голч дүн 3.0-оос дээш тохиолдолд магистрын хөтөлбөрт, магистрын зэргийн боловсролын дипломын голч дүн 3.2-аас дээш тохиолдолд докторын хөтөлбөрт шалгалтгүйгээр элсүүлнэ.

11.16. Шалгалт авах хугацаа, хичээлийн байр болон шалгалттай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг бүртгэл хаагдсанаас хойш 3 хоногт багтаан бүртгүүлэгчийн майл хаяг руу нь илгээнэ.

11.17. Шалгалтанд авбал зохих нийт онооны 60-аас доошгүй хувийг авсан шалгуулагчийг хяналтын тоонд багтаан элсүүлнэ.

11.18. Оноо тэнцсэн тохиолдолд өмнө эзэмшсэн боловсролын дипломын голч дүнг харгалзана.

11.19. Элсэх болзол хангасан элсэгч нь шалгалтын дүн мэдэгдсэн өдрөөс хойш ажлын 5 хоногт багтан Сургалтын бодлого зохицуулалтын албанд дараах материалыг бүрдүүлэн өгнө.

- Удирдлага мэдээллийн системийн суралцагчийн гэрээ болон анкетыг бөглөсөн байх (мэргэжилтэн хэвлэж хавсаргах)
- Магистрантурт бүртгүүлэгч нь бакалаврын зэргийн боловсролын диплом, баталгаажуулсан хуулбарын хамт (Гадаадад их дээд сургууль төгссөн бол Монгол хэл рүү орчуулан нотариатаар гэрчлүүлсэн байна)
- Докторантурт бүртгүүлэгч нь магистрын зэргийн боловсролын диплом, баталгаажуулсан хуулбарын хамт (Гадаадад их дээд сургууль төгссөн бол Монгол хэл рүү орчуулан нотариатаар гэрчлүүлсэн байна)
- 3х4 хэмжээтэй цээж зураг – 3% (сүүлийн 3 сар дотор авхуулсан)
- Иргэний үнэмлэх хуулбар
- Бүртгэлийн хураамж 40000 төгрөг (цахимаар төлөх тул банкны картын E-rin code урьдчилан авсан байх)
- Мэргэшсэн байдлын баримт бичиг, хуулбарын хамт
- Сургалтын төлбөр төлсөн баримт (уян хатан нөхцөлтэй)
- Төр, төрийн бус байгууллага, аж ахуй нэгжид ажилладаг бол ажил байдал, зөвшөөрч, дэмжиж буй тодорхойлолт

11.20. Бүртгэлийн мэдээллийг баримт бичгийн эх хувьтай шалгаж, сургуулийн удирдлага мэдээллийн систем ашиглах эрх авна.

11.21. Элсэлтийн өмнөх шатны боловсролын мэдээлэл нь Боловсролын яамны дээд боловсролын удирдлага мэдээллийн системд баталгаажсан байна.

11.22. Элсэгч нь Этүгэн их сургуулийн Сургалтын нэгдсэн журамд зааснаар сургалтын төлбөрийг төлж хичээлд бүртгүүлэн баталгаажуулах, сургалтын “тэг” долоо хоногт хуваарийн дагуу чиглүүлэх сургалтанд хамрагдана.

АРВАН ХОЁР. БУСАД

12.1. Суралцах эрхийн бичгийг бусдад шилжүүлэхийг хориглоно.

12.2. Хяналтын тоог хангах зорилгоор тухайн мэргэжлээр (хөтөлбөр) бусад сургуульд авдаг шалгалтуудыг харгалзан сургалтын төлбөрийн хөнгөлөлттэйгөөр нэмэлт элсэлт зохион байгуулж болно. Нэмэлт элсэлтийг ([http:// burtgel.etugen.edu.mn/](http://burtgel.etugen.edu.mn/)) цахим хуудсаар болон www.etugen.edu.mn веб сайтаар олон нийтэд мэдээлнэ.

12.3. Бүртгүүлэгч нь энэхүү элсэлтийн журамтай биечлэн танилцсан байх үүрэгтэй.

12.4. Элсэлтийн үйл ажиллагаатай холбоотой аливаа маргааныг Элсэлтийн комисс хүлээн авч шийдвэрлэх бөгөөд комиссын шийдвэртэй санал нийлэхгүй тохиолдолд сургуулийн захиргаанд гомдлоо бичгээр гаргана. Захиргааны зөвлөл 24 цагийн дотор гомдлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

12.5. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан журамд нийцүүлэн элсэлтийг авна.

ХАВСАРГА ХӨТӨЛБӨР

№	Мэргэжил	Хавсарга
1	Анагаах ухаан-Хүний их эмч	<ul style="list-style-type: none"> • Маркетинг • Програм хангамж • Нягтлан бодох бүртгэл • Татварын эдийн засаг, нягтлан бодох бүртгэл • Бизнесийн удирдлага
2	Уламжлалт анагаах ухааны их эмч	<ul style="list-style-type: none"> • Маркетинг • Програм хангамж • Нягтлан бодох бүртгэл • Татварын эдийн засаг, нягтлан бодох бүртгэл • Бизнесийн удирдлага
3	Нүүр ам судлал-шүдний их эмч	<ul style="list-style-type: none"> • Маркетинг • Програм хангамж • Нягтлан бодох бүртгэл • Татварын эдийн засаг, нягтлан бодох бүртгэл • Бизнесийн удирдлага
4	Эм зүй	<ul style="list-style-type: none"> • Маркетинг • Програм хангамж • Нягтлан бодох бүртгэл • Татварын эдийн засаг, нягтлан бодох бүртгэл • Бизнесийн удирдлага
5	Био-Анагаах ухаан	<ul style="list-style-type: none"> • Маркетинг • Програм хангамж • Нягтлан бодох бүртгэл • Татварын эдийн засаг, нягтлан бодох бүртгэл • Бизнесийн удирдлага
6	Төрийн захиргааны удирдлага	<ul style="list-style-type: none"> • Маркетинг • Програм хангамж • Нягтлан бодох бүртгэл • Татварын эдийн засаг, нягтлан бодох бүртгэл • Бизнесийн удирдлага
7	Нягтлан бодох бүртгэл	<ul style="list-style-type: none"> • Маркетинг • Програм хангамж • Бизнесийн удирдлага
8	Хүний нөөцийн менежмент	<ul style="list-style-type: none"> • Маркетинг • Програм хангамж • Нягтлан бодох бүртгэл • Татварын эдийн засаг, нягтлан бодох бүртгэл • Бизнесийн удирдлага
9	Маркетинг	<ul style="list-style-type: none"> • Маркетинг • Програм хангамж • Нягтлан бодох бүртгэл • Татварын эдийн засаг, нягтлан бодох бүртгэл • Бизнесийн удирдлага
10	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний технологи	<ul style="list-style-type: none"> • Маркетинг • Програм хангамж • Нягтлан бодох бүртгэл • Татварын эдийн засаг, нягтлан бодох бүртгэл • Бизнесийн удирдлага
11	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалтын инженер	<ul style="list-style-type: none"> • Маркетинг • Програм хангамж • Нягтлан бодох бүртгэл • Татварын эдийн засаг, нягтлан бодох бүртгэл • Бизнесийн удирдлага

12	Цахилгаан хангамжийн инженер	<ul style="list-style-type: none"> • Маркетинг • Програм хангамж • Нягтлан бодох бүртгэл • Татварын эдийн засаг, нягтлан бодох бүртгэл • Бизнесийн удирдлага
13	Программ хангамжийн инженер	<ul style="list-style-type: none"> • Маркетинг • Нягтлан бодох бүртгэл • Татварын эдийн засаг, нягтлан бодох бүртгэл • Бизнесийн удирдлага
14	Багш, сургуулийн өмнөх боловсрол	<ul style="list-style-type: none"> • Маркетинг • Програм хангамж • Нягтлан бодох бүртгэл • Татварын эдийн засаг, нягтлан бодох бүртгэл • Бизнесийн удирдлага
15	Багш, бага боловсрол	<ul style="list-style-type: none"> • Маркетинг • Програм хангамж • Нягтлан бодох бүртгэл • Татварын эдийн засаг, нягтлан бодох бүртгэл • Бизнесийн удирдлага
16	Бизнесийн удирдлага	<ul style="list-style-type: none"> • Маркетинг • Програм хангамж • Нягтлан бодох бүртгэл • Татварын эдийн засаг, нягтлан бодох бүртгэл
17	Санхүү, банк	<ul style="list-style-type: none"> • Маркетинг • Програм хангамж • Нягтлан бодох бүртгэл • Татварын эдийн засаг, нягтлан бодох бүртгэл • Бизнесийн удирдлага

УР ЧАДВАРЫН ШАЛГАЛТЫН УДИРДАМЖ**НЭГ. ЗОРИЛГО**

1.1. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/143 тоот тушаалаар батлагдсан “Оюутан элсүүлэх журам”-ын 3.2.3-3.2.6 дахь заалтыг үндэслэж, ур чадварын шалгалттай хөтөлбөрт элсэхийг хүсэгчдээс ур чадварын шалгалт авах, ур чадварын шалгалт зохион байгуулагчдыг мэдээллээр хангах, үйл ажиллагааг чиглүүлэхэд оршино.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

2.1. Этүгэн их сургуулийн элсэлтийн бүртгэлд ур чадварын шалгалт шаардагдсан хөтөлбөрт бүртгүүлсэн бүрэн дунд боловсролтой иргэн хамрагдана.

ГУРАВ. ШАЛГАЛТЫН КОМИСС, ТҮҮНИЙ ҮҮРЭГ

3.1. Ур чадварын шалгалтын комиссын бүрэлдэхүүнийг Этүгэн их сургуулийн ректорын тушаалаар томилно. Комисс нь ур чадварын шалгалтыг бүрэн хариуцаж зохион байгуулна.

3.2. Комисст холбогдох мэргэжлийн тэнхимд 3-аас дээш жил ажиллаж байгаа 3-5 багш байна.

3.3. Комисс нь шалгалтын дүнг анхны хэмжээст оноог хэмжээст оноо руу тооцоолж шалгуулагчийн дагалдах шалгалтын оноонд оруулж тооцно.

3.4. Шалгалтын материалыг шалгалтын комисс урьдчилан боловсруулна.

ДӨРӨВ. ХУГАЦАА, БАЙРШИЛ

4.1. Ур чадварын шалгалтыг цахим хэлбэрээр авна. Шалгалтын мэдээллийг элсэлтийн системд бүртгэгдсэн цахим шуудан, холбоо барих дугаараар хүргэнэ.

ТАВ. ШАЛГАЛТЫН ТӨРӨЛ

5.1. Ур чадварын шалгалтыг элсэн суралцах хөтөлбөрийн онцлогтой уялдуулан сорилын хэлбэрээр үнэлнэ.

5.2. Ур чадварын шалгалт авахдаа тодорхой бэлтгэлийн хангаж, шалгалт өгөх иргэнд шаардлагатай мэдээллийг урьдчилан хүргэж ажиллана.

ЗУРГАА. УР ЧАДВАРЫН ШАЛГАЛТЫН ҮНЭЛГЭЭ

6.1. Ур чадварын шалгалтыг 100 хүртэл оноогоор үнэлнэ.

6.2. Уг оноог хэмжээст оноонд дараах байдлаар харгалзуулна.

№	Шалгалтын оноо /Анхны оноо/	Хэмжээст оноо
1	95-100	760-800
2	90-94.9	720-759
3	85-89.9	680-719
4	80-84.9	640-679
5	75-79.9	600-639
6	70-74.9	560-599
7	65-65.9	520-559
8	60-64.9	480-519
9	0-59	200-479

Ур чадварын шалгалтын хэмжээс оноог дагалдах шалгалтын оноогоор тооцно.
Шалгуулагчийн анхны оноо 0-ээс-59-ийн хооронд бол $X=200+A*4.66$

Хэрэв шалгуулагчийн анхны оноо 60-аас 100-ын хооронд бол $X=490+(A-60)*8$ гэсэн томъёогоор олно. 60 буюу 490 болон түүнээс дээш оноо авсан тохиолдолд тухайн ур чадварын шалгалтад тэнцсэн гэж үзнэ.